

АЛСЫН ХАРАА

"НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ХӨТӨЛНӨ" /Хөтөлж өнгөлөх, тэргүүлэх, Хөтөлж чиглүүлэх, Хөтөлж бүртгэх, Хөтөлгөч хүч байх/

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ❖ Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудаа "Чанарын удирдлагын тогтолцоо", үйл ажиллагааны, хэрэгжилт, үр дүн, үйлчилгээний чанараар тэргүүлэгч "МАНЛАЙЛАГЧ БАЙГУУЛЛАГА";
- ❖ Нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, чиглэл өгөх үүрэг бүхий "ЧИГЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА";
- ❖ Нийслэлийн хэмжээнд хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийн санг хөтлөх, дундын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийн санг бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран иргэн, хуулийн этгээдэд хот байгуулалтын мэдээллээр үйлчлэх, мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах үүрэг бүхий "ХӨТЛӨГЧ БАЙГУУЛЛАГА";
- ❖ Хотын стандартын тогтолцоог хөгжүүлж хотын засаглал, бүтээн байгуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээнд дэлхийн жишигт хүрсэн чанарыг нэвтрүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах "ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА";

ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулж батлуулах, хэрэгжилтийг нийслэлийн эдийн засаг, нийгмийн нөөц боломжид тулгуурлан иргэдийн оролцоотой төлөвлөх, хот байгуулалтын үйл ажиллагааг орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн, хуулийн этгээдэд хурдан шуурхай, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах, хяналт тавих.

Бидний эрхэмлэх үнэт зүйлс:

- ❖ **Мэдлэгийг эрхэмлэх:** Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэгээ байнга хөгжүүлнэ.
- ❖ **Чадварыг эрхэмлэх:** Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.
- ❖ **Хууль ёсыг эрхэмлэх:** Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.
- ❖ **Ёс зүйг эрхэмлэх:** Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.
- ❖ **Шударга ёсыг эрхэмлэх:** Газрын үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахдаа аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд орохгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана.
- ❖ **Соёлтой харилцааг эрхэмлэх:** Иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшин, үйл ажиллагаа, үйлчилгээгээ эелдэг, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг байнга авч, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллана.
- ❖ **Үнэнч байдлыг эрхэмлэх:** Төрийн албанд ямагт чин сэтгэлээс хандаж, албан үүргээ аль болох үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвх зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог дүүрэн ашиглаж ажиллана.
- ❖ **Шуурхай байдлыг эрхэмлэх:** Газрын үйл ажиллагааг явуулахдаа бусдад элдэв чирэгдэл учруулахгүй байж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэд нэн анхааралтай хандаж, боломжтой хамгийн бага хугацаанд шийдвэрлэн хариу өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.
- ❖ **Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх:** Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийгээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.
- ❖ **Бүтээлч байдлыг эрхэмлэх:** Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.
- ❖ **Багийн ажиллагааг эрхэмлэх:** Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.

ЧАНАРЫН БОДЛОГО

Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд дэвшилтэт технологид суурилсан хот байгуулалт, төлөвлөлт, хотын стандартыг бий болгож, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийг байнга дээшлүүлж, албан хаагчдыг эрүүл, аюулгүй ажлын байраар хангаж чанарын менежментийн тогтолцооны байнгын сайжруулалтыг хэвшүүлж ажиллана.

ЧАНАРЫН ЗОРИЛГУУД

Зорилго 1. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо (ISO 9001;2015) Олон улсын стандартыг нэвтрүүлж гэрчилгээжүүлэн оновчтой бүтэц, дотоод зохион байгуулалтыг бий болгох, бэхжүүлэх, бие даасан байдлыг хангах, харилцан уялдаатай, шуурхай, бүтээлч хандлагыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

Зорилго 2. Шинэ тутам бий болж байгаа техник технологийн дэвшил, арга аргачлалыг үйл ажиллагаанд нэвтрүүлж тоног төхөөрөмжийн 50 хүртэл хувийг шинэчлэн албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах;

Зорилго 3. Ebarilga цахим порталаар 9 төрлийн 37 үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлтийн үйл явцыг ил тод болгох;

Зорилго 4. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэн шийдвэрлэлтийн хугацааг нэг орон тоонд оруулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх.